

Golomt Capital[®]

ДЭЛХИЙН

ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО
ХОНОГИЙН ТОЙМ

2025.02.10

Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- АНУ руу орж ирэх бүх ган, хөнгөн цагаанд 25%-ийн нэмэлт тариф тогтоохоо зарлав.
- Гангийн хамгийн том экспортлогч орнууд нь Канад, Бразил, Мексик, Өмнөд Солонгос, Вьетнам юм.
- Шударга бус худалдаанд харилцан татвар тогтоохоо мэдэгдэв.
- Европын Холбооны АНУ-ын автомашины импортоос авдаг 10%-ийн тарифыг хүчтэй эсэргүүцэж байсан.
- Хятадын хэрэглээний инфляци нэгдүгээр сард сүүлийн таван сарын хамгийн өндөр түвшинд хүрлээ.
- Хятадын хамгийн том баяр болох Сар шинийн баяр энэ жил нэгдүгээр сард тохиосон нь үнэ өсөхөд нөлөөлсөн байна.



S&P 500 индексийн 2025 оны таамаглал

Deutsche Bank	7,000
Société Générale	6,750
BMO Capital Markets	6,700
Bank of America	6,666
Barclays	6,600
RBC Capital Markets	6,600
Wells Fargo	6,500
Citigroup	6,500
Goldman Sachs	6,500
Morgan Stanley	6,500
JPMorgan Chase	6,500
UBS	6,400
Дундаж	6,678





АНУ-ын зах зээлийн онцлох мэдээ 2025.02.03-02.09

ГАН, ХӨНГӨН ЦАГААНД 25%-ИЙН НЭМЭЛТ



АНУ-ын ерөнхийлөгч Дональд Трамп ням гарагт АНУ руу орж ирэх бүх ган, хөнгөн цагаанд 25%-ийн нэмэлт тариф тогтоохоо зарлаж, мөн өөрийн үзэж буйгаар шударга бус худалдаанд харилцан татвар тогтоохоо мэдэгдэв.

Онгоцонд сэтгүүлчдэд ярилцлага өгөхдөө, Трамп 25%-ийн тарифыг даваа гарагт зарлаж, харилцан татварыг мягмар, лхагва гарагт зарлана гэж хэлсэн бөгөөд хоёулаа нэн даруй хүчин төгөлдөр болох аж.

Ерөнхийлөгч Америкийн хөлбөмбөгийн супер боулд оролцохоор Нью Орлеанс хот руу явж байх үедээ, саяхан "Мексикийн булан"-г "Америкийн булан" хэмээн нэрийг нь өөрчилснөө дурдав.

Ням гарагт Трамп мөн хоёрдугаар сарын 9-нийг "Америкийн булангийн өдөр" болгон зарласан захирамжид гарын үсэг зурав. АНУ-ын ерөнхийлөгч олон улсын өргөн хүрээний бодлогоо хэрэгжүүлэхийн тулд худалдааны хатуу бодлого ашиглаж байна. Бээжин үүний хариуд хэд хэдэн хариу арга хэмжээ авсан.

Тэрбээр Канад, Мексик улсуудыг хилийн хяналтыг чангатгахыг шаардан 25%-ийн тариф тогтоохоор сүрдүүлсэн боловч эдгээр улсуудын өгсөн баталгаанаас үүдэн түр хойшлуулаад байна.

АНУ-ын засгийн газрын мэдээллээс үзвэл, гангийн хамгийн том экспортлогч орнууд нь Канад, Бразил, Мексик, Өмнөд Солонгос, Вьетнам юм. Канад нь АНУ-д хөнгөн цагаан экспортлогч хамгийн том улс хэвээр байна.

Трамп анхны бүрэн эрхийн хугацаандаа ганд 25%, хөнгөн цагаанд 10%-ийн тариф тогтоож байсан боловч Канад, Мексик, Бразил зэрэг холбоотнууддаа татваргүй квот олгож байжээ.

Харилцан татварын талаар Трамп энэ долоо хоногийн сүүлээр хурал зохион байгуулж, харилцан худалдааны татварын талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөхөө мэдэгдэв. Тэрээр энэ төлөвлөгөөгөө анх өнгөрөгч Баасан гарагт зарлаж АНУ-ын индексүүдэд богино хугацаанд хүчтэй уналтыг авчирсан.

Трамп АНУ-ын бараа бүтээгдэхүүнд бусад улсуудын тавьж буй тэгш бус импортын татварыг удаа дараа шүүмжилж ирсэн. Ялангуяа Европын Холбооны АНУ-ын автомашины импортоос авдаг 10%-ийн тарифыг хүчтэй эсэргүүцэж байсан нь тодорхой. Учир нь АНУ зөвхөн 2.5%-ийн импортын татвар ногдуулдаг.

Гэхдээ эдийн засагчид болон Холбооны Нөөцийн Сангийн албаныхан Трампын худалдааны татваруудын үр дагаварт санаа зовниж буйгаа илэрхийлсэн. АНУ-ын импортлогчид эдгээр татварын ачааг үүрэх тул инфляцыг өсгөх эрсдэлтэй гэж үзэж байна.



Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ 2025.02.03-02.09

ХЯТАДЫН ИНФЛЯЦ ӨНДӨР ГАРЛАА



Хэрэглээний үнийн индекс өнгөрсөн сард жилийн өмнөхтэй харьцуулахад 0.5%-иар өссөн нь Ройтерс агентлагийн эдийн засагчдын таамаглаж байсан 0.4%-ийн өсөлтөөс өндөр гарчээ. Урт хугацааны инфляцын чиглэлийг тодорхойлогч үндсэн инфляци нэгдүгээр сард 0.6% болж, өмнөх сарын 0.4%-иас нэмэгдсэн байна.

Хятадын хэрэглээний инфляци нэгдүгээр сард сүүлийн таван сарын хамгийн өндөр түвшинд хүрсэн. Гэхдээ үйлдвэрүүдийн түүхий эдийн эрэлт сул тул үйлдвэрлэгчдийн үнийн индекс бага хэвээр байна. Энэ нь өнгөрсөн сард хэрэглэгчдийн худалдан авалт их байсан ч үйлдвэрлэл тааруу байсныг илэрхийлнэ.

Гэхдээ Хятадын хамгийн том баяр болох Сар шинийн баяр энэ жил нэгдүгээр сард тохиосон нь хэрэглэгчдийн үнэ өсөхөд, мөн үйлдвэрлэл сул байхад нөлөөлсөн байна. Ихэнхдээ хэрэглэгчид баярын томоохон цугларалтад зориулж хүнсний бүтээгдэхүүн, бусад барааг их хэмжээгээр худалдан авдаг тул үнэ өсдөг.

Хэрэв засгийн зүгээс дотоодын сул эрэлтийг дахин сэргээж чадахгүй бол дефляцийн дарамт энэ онд Хятадад үргэлжлэх төлөвтэй гэж шинжээчид үзэж байна. Үүнээс гадна, АНУ-ын ерөнхийлөгч Дональд Трампын Хятадын бараа бүтээгдэхүүнд ногдуулсан тариф нь эдийн засгийн өсөхөд нэмэлт дарамт учруулж байна.

ХЯТАД АНУ-Д ЗҮГЭЭР ХАРААД ДЭЭРЭЛХҮҮЛЭХГҮЙ



Хятад улс АНУ-ын 10%-ийн нэмэлт тарифыг “нэг талт дарамт” хэмээн буруутгаж, 15%-ийн хариу татвар (LNG болон зарим бараанд) ногдуулахаа мэдэгдлээ. De minimis хөнгөлөлт цуцлагдсанаар Хятадын цахим худалдааны худалдаачид хүнд байдалд орж болзошгүй. АНУ-ын de minimis хөнгөлөлтийн хүрээнд Хятадын жижиглэн худалдааны компаниуд татваргүй экспорт хийх боломжтой байсан ч энэ хөнгөлөлт цуцлагдсанаар өртөг нэмэгдэх эрсдэлтэй. Бээжин худалдааны шударга орчин бүрдүүлэхийг АНУ-аас шаардав.

DEESPEEK = MAKE CHINA GREAT AGAIN



Хиймэл оюун ухааны DeepSeek загварын амжилт Хятадын тэргүүлэх технологийн компаниудын үнэлгээнд эерэг нөлөө үзүүлж, зах зээлд шинэ хандлага бий болгож байна. Alibaba-гийн хувьцаа өнгөрсөн долоо хоногт 13% өсөж, Хонгконгийн Hang Seng Tech Index 9%-ийн өсөлттэйгээр "булл" зах зээлд орлоо.

Хятадын технологийн компаниудын үнэлгээ АНУ-ын өрсөлдөгчдөөс хямд байна (Nasdaq 100: 27x, Hang Seng Tech Index: 17x). Гол тоглогчид болох Alibaba, Tencent (Hunyuan), Baidu (Ernie Bot), ByteDance (Doubao) бүгд AI загваруудаа сайжруулж байна. AI хөгжихийн хэрээр Alibaba, Tencent зэрэг компанийн үүлэн тооцооллын эрэлт нэмэгдэнэ.

Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд

E EARNINGS WHISPERS Most Anticipated Earnings Releases for the week beginning February 03, 2025									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	Before Open
 SAIA	 Palantir	 PayPal	 AMD	 Uber	 Qualcomm	 Lilly	 amazon	 COCA-COLA	 CANOPY GROWTH
 TSN	 kyndryl	 Spotify	 Alphabet	 Disney	 Ford	 ROBLOX	 elf	 PLAINS ALL AMERICAN PIPELINE	 Flowers FOODS
 ALLIANCE RESOURCE PARTNERS, LP	 DOC	 PEPSICO	 Snap Inc.	 VIVO	 arm	 PELOTON	 CLOUDFLARE	 newell BRANDS	 avantor
 TWIST	 NXP	 Pfizer	 CHIPOTLE	 equinor	 symbotic	 ConocoPhillips	 affirm	 byrna	 Cboe
 IDEXX LABORATORIES	 The Clorox Company	 REGENERON	 ENPHASE	 TOYOTA	 amsc	 HERSHEY	 FORTINET	 avantor	 byrna
 LAVORO	 RBB BANCORP	 MERCK	 AMGEN	 Boston Scientific	 VIKING THERAPEUTICS	 tapestry	 Pinterest	 GRAFTech	 FORTIVE
 JOHNSON OUTDOORS	 belling	 ESTÉE LAUDER COMPANIES	 Electronic Arts	 StanleyBlack&Decker	 O'Reilly AUTO PARTS	 MICROCIP	 POWELL	 KIMCO	
 KYOCERA	 fabrinet	 LUMEN	 LUMEN	 CDW	 IMPINJ	 BLUE OWL	 POWELL	 FORTIVE	
 muRata	 Rambus	 Enterprise Products Partners LP	 JUNIPER NETWORKS	 Johnson Controls	 MetLife	 Bristol Myers Squibb	 VictoryCapital	 KIMCO	
 NAPCO	 Mitek	 APOLLO	 Prudential	 AURORA	 align	 BCE	 T2		

<http://eps.sh/cal>

© 2025 Earnings Whispers

Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд

E EARNINGS WHISPERS Most Anticipated Earnings Releases for the week beginning February 10, 2025									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	Before Open
 McDonald's	 AsteroLabs	 shopify	 SUPERMICRO	 VERTIV	 reddit	 DATADOG	 coinbase	 moderna	
 monday.com	 VERTEX	 Coca-Cola	 Upstart	 CVS Health	 Robinhood	 crocs	 twilio	 ENBRIDGE	
 onsemi	 FLUENCE	 Humana	 DOORDASH	 BARRICK	 APPLOVIN	 JOHN DEERE	 DRAFT KINGS	 AMERICAN AXE & MANUFACTURING	
 Tower Semiconductor	 LATTICE	 bp	 lyft	 GENERAC	 Dutch Bros	 CYBERARK	 APPLIED MATERIALS	 MAGNA	
 Rockwell Automation	 axcelis	 AutoNation	 ENERGY TRANSFER	 Tenet Health	 theTradeDesk	 PPG	 airbnb	 Portland General Electric	
 GCM GROSVENOR	 Amkor Technology	 S&P Global	 freshworks	 Biogen	 ALBEMARLE	 SONY	 paloalto	 AMC NETWORKS	
 Incyte	 MEDPACE	 leidos	 GILEAD	 Dominion Energy	 KINROSS	 GE HealthCare	 Roku	 AIR CANADA	
 CNA	 arrowhead	 CERAGON	 CONFLUENT	 Kraft Heinz	 CISCO	 DUKE ENERGY	 Wynn	 FORTIS	
 Alexander's Inc.	 Inspire	 THE CARVILLE GROUP	 ZILLOW GROUP	 Camtek	 aspen aerogels	 ZEBRA	 Harsco MINING COMPANY	 LIVE XONE	
 Edgewell	 Mitek	 Marriott International	 AIG	 Me Cooper Group	 MGM RESORTS	 HOWMET AEROSPACE	 REPUBLIC SERVICES	 NEWMARK	

<http://eps.sh/cal>

© 2025 Earnings Whispers